



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар A/210


Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын Х хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолын тавдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан “Аймгийн хэмжээнд ерөнхий агнуур зохион байгуулалт” хийлгэх зөвлөх сонгох үнэлгээний хорооны 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01 дугаартай зөвлөмжийн дагуу Монголын анчдын нийгэмлэг төрийн бус байгууллагатай 19 713 375 /арван есөн сая долоон зуун арван гурван мянга гурван зуун далан тав/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т олгосугай.
2. Монголын анчдын нийгэмлэг төрийн бус байгууллагын ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, журам, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.
3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг Монголын анчдын нийгэмлэг төрийн бус байгууллага /Ж.Жаргал/-д үүрэг болгосугай.
4. Гэрээт ажлын санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З БАТЗОРИГ

D:\ЗДТГ,ХОХБТХ\Захирамж

20190218